
	(ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллеж)	Захирлын 2026 оны 02 дугаар сарын 10-ны өдрийн ...¹¹/₁₂... тоот тушаалын хавсралт	
Баталсан: ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал  (Ч.Эрдэнэтуяа)		Баталсан огноо: 2026.02.10	Хуудасны тоо: 4
Баримт бичгийг хариуцагч: Захирлын туслах, архив бичиг хэрэг хариуцсан ажилтан		Танилцах албан тушаалтнууд: Нийт багш, ажилчид	

НЭГДМЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЖУРАМ, БОДЛОГО

Эх хувь

Баримтжуулсан мэдээллийн дугаар:
Хувилбарын дугаар: **V1.2026**

Түгээлт



Энэ журам нь манай байгууллагын өмч юм. Уг баримт бичгийг бичгээр зөвшөөрөл аваагүй үед бүхэлд нь эсвэл хэсэгчлэн байгууллагаас гадагш түгээхгүй.

Энэ журмын батлагдсан албан ёсны хяналттай хуулбар нь цаасан хэлбэрээр бичиг хэргийн ажилтны баримт бичгийн хавтсанд мөн байгууллагын сервер компьютерт PDF файлаар хадгалагдана. Уг PDF файл зөвшөөрөгдсөн бүх ажилтнууд болон сонирхогч талуудад нээлттэй байна.

Дээр дурдсанаас бусад бүх цаасан болон цахим хуулбарыг зөвхөн лавлагаа болгон ашиглах хяналтгүй хуулбар гэж үзнэ.

ЗӨВШӨӨРӨЛ

Гарын үсэг нь удирдлагын тогтолцооны энэхүү журмыг хянаж, зөвшөөрснийг гэрчлэх бөгөөд гарын үсэг зурсан талууд энд агуулагдаж буй бүх шаардлагуудыг мэдэж, тэдгээрийн хэрэгжилтийг хангах үүрэг хүлээсэн болохыг харуулна.

	Албан тушаал	Овог нэр	Огноо	Гарын үсэг
Боловсруулсан	ДЧБСХААжилтан	Энх-Амгалан Шинэжаргал	2026.01.08	
Хянасан	Сургалтын менежер	Лувсандорж Чингэрэл	2026.01.20	
Зөвшөөрсөн	ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа Политехник коллежийн Захирал	Чимэд Эрдэнэтуяа	2026.01.27	

НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТИЙН БҮРТГЭЛ

Журмын өөрчлөлт нь процесс болон бусад бодлогын баримт бичгүүдтэй уялдаж байгаа эсэхийг хянаж баталгаажуулна. Өөрчлөлтийн агуулга хэсэгт журамд орсон өөрчлөлтийг тэмдэглэнэ.

Өөрчлөлт оруулсан бүлэг	Өөрчлөлтийн товч утга	Хувилбарын дугаар	Сүүлд шинэчлэгдсэн огноо	Боловсруулж, шинэчилсэн албан тушаалтан, овог, нэр	Баталсан албан тушаалтан, овог, нэр

АГУУЛГА

НЭГ.Нийтлэг үндэслэл.....	1
ХОЁР.Хамрах хүрээ.....	1
ГУРАВ.Бодлогын тодорхойлолт.....	1
ДӨРӨВ.Бодлогын зорилт	1-2
ТАВ. Нэр томъёоны тодорхойлолт	2-3
ЗУРГАА.Хариуцлага, эрх үүрэг.....	3
ДОЛОО.Бодлогын зарчим	3-4
НАЙМ.Хэрэгжилт ба хяналт	4
ЁС.Маягт.....	4



Нэг.Нийтлэг үндэслэл

1. Энэхүү бодлого Политехник коллежийн чанарын менежментэд өгч буй амлалт зарчмыг илэрхийлэхэд оршино.

2. “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Политехник коллежийн хөгжлийн дунд хугацааны хөтөлбөр (2024-2028)”, **ISO 9001:2015** — Чанарын удирдлагын тогтолцоо, **ISO 14001:2015** — Байгаль орчны менежментийн тогтолцоо, **ISO 45001:2018** — Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо нь энэхүү бодлогын эрх зүйн үндэслэл болно.

Хоёр.Хамрах хүрээ

2.1.Бодлого нь ШУТИС-ийн Өмнөговь аймаг дахь Технологийн дээд сургуулийн харьяа политехник коллежийн болон түүний үйл ажиллагаанд оролцогч, сонирхогч талуудад хамаарна.

2.1.1.хичээл сургалтын бүх үйл явц;

2.1.2.хлон нийтэд чиглэсэн ажил /нийт багш ажилчид, суралцагчид;

2.1.3.аж ахуйн холбогдолтой ажлууд болон бүх шатны удирдлага, багш, ажилчид, оюутан суралцагчид, хамтрагч байгууллага, зочид,үйлчлүүлэгч нар хамрана;

Гурав.Бодлогын тодорхойлолт

3.1.Эрүүл, аюулгүй, байгаль орчинд ээлтэй орчинд чанартай боловсролын үйлчилгээг тасралтгүй сайжруулж, ажилтан, суралцагч болон талуудын оролцоог дэмжинэ.

Дөрөв.Бодлогын зорилт

4.1.Чанарын удирдлагын тогтолцоо (ISO 9001:2015) зорилтууд. Үүнд:

4.1.1.суралцагчдын хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн чанартай боловсролын үйлчилгээг тогтмол сайжруулах;

4.1.2.сургалтын үр дүн, багшийн арга зүй, хэрэглэгдэхүүн, сургалтын дэд бүтэц зэрэгт хяналт, үнэлгээ хийх тогтолцоог хөгжүүлэх;

4.1.3.сонирхогч талуудын сэтгэл ханамжийг тогтмол үнэлж, санал, дүгнэлтэд тулгуурлан арга хэмжээ авах;

4.1.4.инновац, дижитал технологийг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж, боловсролын чанарыг дээшлүүлэх;



4.2. Байгаль орчны удирдлагын тогтолцоо (ISO 14001:2015) зорилтууд

4.2.1. сургалтын үйл ажиллагаанаас үүсэх хаягдал, эрчим хүч, усны хэрэглээг бууруулах, байгальд ээлтэй технологийг нэвтрүүлэх;

4.2.2. байгаль орчны хууль, дүрэм, зохицуулалтын шаардлагыг чанд мөрдөх;

4.2.3. байгаль орчны эрсдэл, нөлөөллийг тогтмол үнэлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх;

4.2.4. суралцагч, багш, ажилтнуудыг байгаль орчны мэдлэг, хариуцлагад сурган, оролцоог дэмжих;

4.3. Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо (ISO 45001:2018) зорилтууд

4.3.1. ажилтан, суралцагчдын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх; осол, гэмтлээс урьдчилан сэргийлэх;

4.3.2. ХАБЭА-н хууль, дүрэм, журмыг мөрдүүлж, аюулын үнэлгээ, эрсдэлийн удирдлагыг тогтмол хэрэгжүүлэх;

4.3.3. ажилтны оролцоо, сургалт, мэдээлэл, хяналт-шинжилгээг хөгжүүлж, ХАБЭА-н соёлыг төлөвшүүлэх;

4.3.4. эрсдэл бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг тасралтгүй сайжруулж, гүйцэтгэлийн үзүүлэлтийг дээшлүүлэх;

Тав. Нэр томъёоны тодорхойлолт

Нэгдмэл менежментийн тогтолцооны бодлого: Байгууллагын үйл ажиллагааг чанартай, үр дүнтэй, тогтвортой байлгаж, байгаль орчинд ээлтэй, эрүүл аюулгүй орчныг хануулахын зэрэгцээ ажилтан, суралцагч, сонирхогч талуудын оролцоог дэмжиж, хүлээлтэд нийцсэн үйл ажиллагаа явуулах замаар үр дүн, эрсдэл, сайжруулалтын үйл явцыг тасралтгүй хянаж, сайжруулах боломж, зорилго чиглэл

Нэгдмэл менежментийн тогтолцооны зорилт: Тогтолцооны талаар хийхээр буюу хүрэхээр зорьж, эрмэлзсэн зүйлс. Энэ нь **Нэгдмэл менежментийн тогтолцооны бодлогыг** хэрэгжүүлэхийн тулд дэвшүүлсэн ажлын төлөвлөгөө юм

Боловсролын үйлчилгээ: Сургах, суралцах, судлах замаар суралцагчдад чадамж (мэдлэг, ур чадварыг ашиглах чадвар)-ийг эзэмшүүлэх, хөгжүүлэхийг дэмжих үйл явц.



Хэрэглэгчийн сэтгэл ханамж: Боловсролын байгууллагын хэрэглэгч буюу суралцагч, тэдний эцэг эх, ажил олгогч, ажилтны шаардлага биелэгдсэн түвшин

Зургаа.Хариуцлага, эрх үүрэг

6.1.Өмнөговь политехник коллежийн захирал бодлого зорилтыг тушаалаар баталгаажуулна.

6.2.Өмнөговь политехник коллежийн захирлын дэргэдэх зөвлөл:

6.2.1.Бодлогын нийцэл, тохиромжтой байдалд 2 жил тутамд дүн шинжилгээ хийнэ;

6.2.2.Бодлогын зорилтод хүрэх төлөвлөгөөний хэрэгжилт болон үр дүнд жил бүр дүн шинжилгээ хийнэ;

6.2.3.Бодлого, зорилтыг үнэлж, зөвлөмж гаргана;

6.3.Дотоод чанарын баталгаажилт статистик хариуцсан ахлах ажилтан:

6.3.1.Чанарын бодлогын нийцэл, тохиромжтой байдалд дүн шинжилгээ хийх ажлыг санаачлан, хэлэлцүүлнэ;

6.3.2.Чанарын зорилтын хэрэгжилт, үр дүнг үнэлж тайлагнана;

6.3.3.Чанарын бодлого, зорилтод өөрчлөлтийг тусгаж, боловсруулна;

6.3.4.Чанарын бодлого, зорилтыг их сургуулийн хэмжээнд мэдээлж, ойлгуулан, хүртээмжтэй байлгана;

6.4.Ниит багш ажилчид:

6.4.1. Бодлого, зорилтыг ойлгож, хэрэгжүүлж ажиллана;

6.4.2.Алба, нэгж бүр хичээлийн жилийн ажлын төлөвлөгөөнд холбогдох чиг үүргийн дагуу зорилтыг нарийвчлан тусгаж, төлөвлөнө;

Долоо.Бодлогын зарчим

7.1.Суралцагч, тэдний эцэг эх ажил олгогч, ажилтнуудын хүлээлт ба хэрэгцээнд төвлөрнө.

7.2.Сургуулийн менежментийн тогтолцоонд хүн бүрийг оролцуулж, тэдний чадамжийг хөгжүүлнэ.

7.3.Үйл ажиллагааг ойлгомжтой, харилцан уялдаатай (дэс дараалал) болгоход үйл явцын арга, хандлагыг ашиглана.

7.4.Гүйцэтгэлийг хянаж, тасралтгүй сайжруулна.

7.5.Өгөгдөл, мэдээллийн дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргана.



- 7.6.Харилцан ашигтай хамтын ажиллагааг эрхэмлэнэ.
- 7.7.Нийгмийн өмнө хариуцлагатай байна.
- 7.8.Боловсролын бүтээгдэхүүн үйлчилгээг хүртээмжтэй, эрх тэгш байлгана.
- 7.9.Мэдээллийн аюулгүй байдал, хамгаалалтыг хангана.
- 7.10.Боловсролын ёс зүйн хэм хэмжээг баримтална.

Найм.Хэрэгжилт ба Хяналт

8.1.Бодлогын хэрэгжилт, зорилтуудыг жил бүр тодорхойлж, хэмжиж, дүн шинжилгээ хийнэ.

8.2.Сонирхогч талуудын хэрэгцээ, хүлээлт, хууль эрх зүйн шаардлага, эрсдэлийн үнэлгээнд үндэслэн төлөвлөгөө боловсруулна.

8.3.IMS-ийн бодлогыг байгууллагын бүх ажилтан, багш, суралцагч хэрэгжүүлэх үүрэгтэй.

8.4.Бодлогыг байгууллагын дотоод сүлжээ, самбар, цахим хуудсаар дамжуулан олон нийтэд түгээж ойлгомжтой байдлаар хүргэнэ.

Ёс.Маягт


9.1.Т-6-005- Нэгдмэл менежментийн тогтолцооны зорилт хэрэгжүүлэх төлөвлөгөөний маягт



№ Т-6-005
Нэгдмэл менежментийн тогтолцооны
зорилт хэрэгжүүлэх төлөвлөгөөний маягт
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн
санд

Баталсан огноо: 2026-02-10
Хувилбар: V1.2026
Нууцын зэрэг: Нээлттэй

БАТЛАВ

ШИНЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТЕХНОЛОГИЙН ДЭЭД СУРГУУЛИЙН
ХАРЬАА ПОЛИТЕХНИК КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ  Ч.ЭРДЭНЭТУЯА

..... оны сарын

НЭГДМЭЛ МЕНЕЖМЕНТИЙН ТОГТОЛЦООНЫ ЗОРИЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Стандарт	Зорилт	Хэрэгжүүлэх арга зам	Хүрэх үр дүн	Оролцоо
ISO 9001:2015	Суралцагчдын хэрэгцээ, хүлээлтэд нийцсэн чанартай боловсролын үйлчилгээг тогтмол сайжруулах	Суралцагчдын хэрэгцээ, санал асуулгыг онлайн цуглуулах - Суралцагчдын санал асуулгыг биечлэн цуглуулах - Хөтөлбөр, сургалтын төлөвлөгөөг улирал бүр үнэлж шинэчлэх - Багшийг шинэ арга зүй, инновацийн сургалтад хамруулах	Суралцагчдын сэтгэл ханамж $\geq 85\%$; Шинэчилсэн хөтөлбөрийн хувь $\geq 90\%$	Багш, удирдлага, суралцагчид
ISO 9001:2015	Сургалтын үр дүн, багшийн арга зүй, сургалтын дэд бүтэц, хэрэглэгдэхүүнд хяналт, үнэлгээ хийх	Дотоод аудит, сургалтын үр дүнгийн шинжилгээг хагас болон бүтэн жилээр хийх - Сургалтын материал, хэрэглэгдэхүүний чанарыг стандарттай нийцүүлэн үнэлэх - Сургалтын үр дүнг багш, суралцагчийн саналтай холбох	Сургалтын чанарын үнэлгээ $\geq 90\%$; Дотоод аудитын тайлан 100% гүйцэтгэлтэй	Дотоод аудитын баг, багш нар
	Сонирхогч талуудын сэтгэл ханамжийг үнэлж, санал,	- Санал хүсэлт, гомдлыг онлайн систем болон сурагчаа сонсох өдрөөр цуглуулах - Төлөвлөгөө гарган санал	Санал, гомдлын шийдэл $\geq 95\%$; Сэтгэл ханамж $\geq 85\%$	Удирдлага Суралцагчид, багш, ажилтнууд



№ Т-6-005
Нэгдмэл менежментийн тогтолцооны
зорилт хэрэгжүүлэх төлөвлөгөөний маягт
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн
санд

Баталсан огноо: 2026-02-10
Хувилбар: V1.2026
Нууцын зэрэг: Нээлттэй

ISO 9001:2015	дүгнэлтэд тулгуурлан арга хэмжээ авах	болгосон шийдлийг хэрэгжүүлэх - Үр дүнг улирал тутам удирдлагад танилцуулах		
ISO 9001:2015	Инновац, дижитал технологийг сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлэх	- Онлайн сургалтын платформ нэвтрүүлэх - Багшийг дижитал сургалтын хэрэгсэлд сургах - Инновацийн төсөл санаачилгыг дэмжих, батлагдсан 5 санааг хэрэгжүүлэх	Онлайн сургалтын хамралт $\geq 70\%$; Инновацийн санаа хэрэгжүүлсэн ≥ 5 төсөл/жил	Удирдлага Суралцагчид, багш
ISO 14001:2015	Сургалтын үйл ажиллагаанаас үүсэх хаягдал, эрчим хүч, усны хэрэглээг бууруулах	Эрчим хүч, усны хэрэглээг хянах - Хог хаягдлыг ангилан ялгах, дахин боловсруулах систем бий болгох - Байгальд ээлтэй технологи, LED гэрэлтүүлэг, ус хэмнэх төхөөрөмж ашиглах	Эрчим хүчний хэрэглээ буурсан $\geq 10\%$; Хаягдлын ангилан ялгах систем хувь $\geq 90\%$	Суралцагч, багш, ажилтан, үйлчилгээний ажилтнууд
ISO 14001:2015	Байгаль орчны хууль, дүрэм, зохицуулалтын шаардлагыг чанд мөрдөх	- Холбогдох хууль, дүрэмт баримт бичгийг цахим системээр хянах - Жил бүр байгаль орчны аудит хийх - Зөрчил илэрвэл 30 хоногийн дотор засварлах	Зөрчилгүй тайлан 100%	Ногоон баг
ISO 14001:2015	Байгаль орчны эрсдэл, нөлөөллийг үнэлж, урьдчилан сэргийлэх	- Байгууллагын бүхий л үйл ажиллагааны эрсдэлийг тодорхойлох - Урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх - Үр дүнг тайлангаар хянах	Эрсдэлийн тоо буурсан $\geq 20\%$; Урьдчилан сэргийлэх арга хэмжээ 100% хэрэгжсэн	Ногоон баг багш, ажилтнууд
ISO 14001:2015	Суралцагч, багш, ажилтнуудыг байгаль орчны мэдлэг, хариуцлагад сургах	Байгаль орчны сургалт зохион байгуулах (жилд 2 удаа) - Мэдлэг, хариуцлагын шалгалт авах - Эко өдөр, төсөл арга хэмжээг зохион явуулах	Оролцоо $\geq 90\%$; Мэдлэгийн шалгалт $\geq 80\%$	Багш, ажилтнууд
ISO 45001:2018	Ажилтан, суралцагчдын эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх	- Аюул эрсдэлийн үнэлгээ хийх, шинэ аюулыг тодорхойлох - Осол, гэмтлийг урьдчилан сэргийлэх	Осол гэмтлийн тоо 0; Хяналт шалгалт $\geq 95\%$	ХАБЭА баг, ажилтнууд, суралцагчид



№ Т-6-005
Нэгдмэл менежментийн тогтолцооны
зорилт хэрэгжүүлэх төлөвлөгөөний маягт
Хадгалалт: Эх хувь, байгууллагын мэдээллийн
санд

Баталсан огноо: 2026-02-10
Хувилбар: V1.2026
Нууцын зэрэг: Нээлттэй

		хяналт хийх - Аюулгүй ажиллагааны зааврыг тогтмол шинэчлэх		
ISO 45001:2018	ХАБЭА-н хууль, дүрэм, журмыг мөрдүүлж, эрсдэлийг удирдах	- Холбогдох хууль, дүрмийг байнга шинэчлэх - Эрсдэлийн үнэлгээ, хяналт хийж тайлагнах	Эрсдэлийн үнэлгээний гүйцэтгэл 100%; Зөрчилгүй тайлан 100%	ХАБЭА баг, Удирдлага
ISO 45001:2018	Ажилтны оролцоо, сургалт, мэдээлэл, хяналт- шинжилгээг хөгжүүлэх	- ХАБЭА сургалт, дадлага сургалт явуулах - Мэдээлэл, зөвлөмж, саналыг системтэй хүргэх	Оролцоо $\geq 90\%$; Сургалтын амжилт $\geq 85\%$	Багш, ажилтнууд
ISO 45001:2018	Эрсдэл бууруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг сайжруулж гүйцэтгэлийг дээшлүүлэх	- Урьдчилан сэргийлэх арга хэмжээг шинэчлэх - Гүйцэтгэлийн мониторингийг хагас жилд нэг удаа хийх - Тайлан, дүгнэлтээр үр дүнг үнэлэх	Эрсдэл 20%-иар буурсан; Хяналт шалгалтын тайлан 100%	ХАБЭА баг, удирдлага